



Хэрэглэгчийн гарын авлага

УС БУЦАЛГАГЧ

ЗАГВАР: RKEFG64GG



Хэрэглэхээс өмнө зааварчилгаатай сайтар танилцана уу

Баталгаат засварын хуудас нь худалдан авсан барааны төлбөрийн баримтын хамт хүчинтэй тул анхаарч, хадгалахыг зөвлөж байна.

Rotenzo брэндийн ус буцалгагчийг сонгосонд баярлалаа.

Гарын авлагыг хэрэглэгч та бүхэнд бүтээгдэхүүнийг зөв, бүрэн гүйцэд ашиглахад туслах үүднээс бэлтгэв. Уг бүтээгдэхүүнийг ашиглахын өмнө гарын авлагатай танилцана уу!

Хэрэглэгчийн гарын авлагатай танилцсаны дараа бүтээгдэхүүний гэмтэл засвар болон гарч болзошгүй гэмтлийг засварлах үүднээс гарын авлагыг хадгална уу!

Бусдад дамжуулахаар бол гарын авлагыг хамтад нь өгнө үү!

ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

ЗАГВАР	RKE164GT11
Багтаамж	1.7 л
Цахилгаан зарцуулалт	1850-2200 Вт
Хүчдэл	220-240 В, 50-60 Гц

АЮУЛГҮЙН АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

- Энэхүү зааврыг анхааралтай уншиж танилцаад дагаж мөрдөнө үү.
- Энэхүү гарын авлагын дагуу ус буцалгагчийг ажиллуулна уу.
- Ус буцалгагчийг бага насны хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд бие даан ашиглахыг хориглоно. Ашиглах тохиолдолд асран хамгаалагчийн заавар зөвлөгөөний дагуу хэрэглэнэ.
- Ус буцалгагч эвдэрч гэмтсэн тохиолдолд мэргэжлийн засварчинд хандана уу.

1. Цахилгаан болон халалтын заавар

- Ус буцалгагчийг зөвхөн заасан цахилгаан хүчдэлд залгана уу.
- Ус буцалгагчийг ашиглаагүй үедээ цахилгааны эх үүсвэрээс салгана уу.
- Ус буцалгагчийг цахилгаанаас салгахдаа залгуурын толгой хэсгээс барьж салгах ба залгуурын утаснаас татаж салгаж болохгүй.
- Ус буцалгагч ажиллаж байх үедээ их бие нь халах учир түлэгдэж, гэмтэхээс сэргийлнэ үү.
- Ус буцалгагчийн залгуур эвдэрсэн тохиолдолд ус буцалгагчийг ашиглаж болохгүй, зөвхөн мэргэжлийн засварчинд хандана уу.
- Ус буцалгагчийн залгуур хайлсан тохиолдолд ажиллуулж болохгүй.
- Ус буцалгагчийг галын аюулаас урьдчилан сэргийлэх үүднээс шатамхай зүйлтэй ойр байлгаж болохгүй.
- Ус буцалгагчийг бүтээж, хааж болохгүй ба задгай орчинд ашиглана уу.

- Ус буцалгагчийн залгуурыг хэт халуун зүйлд ойр байлгаж болохгүй.

2. Ашиглалтын заавар

- Ус буцалгагчийг зөвхөн ахуйн хэрэгцээнд ашиглана уу.
- Ус буцалгагчийг тэгш гадаргуутай зүйл дээр байршуулна уу.
- Ус буцалгагчийг ашиглаж дууссаны дараа болон цэвэрлэгээ хийхдээ залгуурыг цахилгааны эх үүсвэрээс салгана уу.
- Ус буцалгагчийг зөөж тээвэрлэхдээ залгуураас татаж, залгуураас өлгөж болохгүй.
- Нойтон гараар цахилгааны залгуурт хүрвэл цахилгаанд цохиулах эрсдэлтэй.
- Ус буцалгагчийг хэт чийгтэй, нойтон газарт ашиглаж болохгүй.
- Залгуурыг шингэн зүйлд дүрж, норгож болохгүй.
- Хэрвээ ус буцалгагч ус руу унасан бол эхлээд залгуурыг цахилгаанаас салгаж, дараа нь уснаас гаргаж авна. Усанд унасан ус буцалгагчийг дахин ашиглаж болохгүй.
- Зөвхөн ус буцалгагчтай хамт ирсэн зориулалтын суурийг ашиглана уу.
- Ус буцалгагчийг сууринаас авч усаар дүүргэнэ. Усыг “max” түвшнээс хэтэртэл дүүргэж болохгүй.
- Усгүй үед бүтээгдэхүүнийг ашиглаж болохгүй. Зөвхөн хүйтэн ус хийнэ үү.
- Ус буцалгагчийг ажиллуулахдаа аюулгүй ажиллагааны үүднээс ус буцалгагчийн тагийг хаалттай байлгана уу.
- Ус буцалж байх үед ус буцалгагчийн тагийг авч болохгүй.
- Ус буцалгагчийг зөвхөн ус буцалгах болон халаахад ашиглана. Бусад төрлийн шингэн халааж, буцалгаж болохгүй.
- Ус буцалгагчинд хамгийн багадаа 0.5 л ус хийнэ.

БҮТЭЦ ЭД АНГИ

1. Таг
2. Шүүлтүүртэй цорго
3. Шилэн их бие
4. Гэрэлтүүлэг
5. Суурь
6. АСААХ/ УНТРААХ товчлуур
7. Бариул
8. Ус хэмжигч
9. Таг онгойлгох товчлуур



I. АШИГЛАЛТ

Энэхүү ус буцалгагч нь зөвхөн ахуйн хэрэглээний зориулалттай бөгөөд бусад зориулалтаар ашиглах нь тохиромжгүй.

1. Анх удаа хэрэглэхэд

Ус буцалгагчийг анх удаа ашиглахдаа үйлдвэрлэлийн үйл явцаас үүссэн бохирдлыг цэвэрлэх үүднээс 3 удаа ус дүүргэн буцалгана уу. Бусалсан усыг шууд асгана уу.

ЗӨВЛӨГӨӨ: Анх удаа хэрэглэхдээ цууны уусмал болон тусгай ус буцалгагч ашиглан цэвэрлэж болно.

2. Хэрэглээ ба ашиглалт

- Ус буцалгагчийн тагийг өөрийн эсрэг зүг рүү нээнэ үү.
- Ус буцалгагчид шаардлагатай хэмжээний ус хийнэ үү (хамгийн багадаа 0.5 л, хамгийн ихдээ 1.7 л ус хийнэ).
- Усны түвшинг "тах" түвшнээс хэтрүүлэн дүүргэж болохгүй, буцалсан халуун ус хальж асгах эрсдэлтэй.

3. Санамж

- Ус буцалгагчийн суурин дээр ус тогтоож болохгүй, ямагт хуурай байлгана уу.
- Ус буцалгагчийн тагийг нээхдээ зориулалтын товчлуурыг ашиглана уу.
- Усны буцалгагчийн их биеийг суурин дээр байрлуулж залгуурыг залгана. АСААХ/УНТРААХ товчлуурыг доош дарж асаана. АСААХ/УНТРААХ ажиллагааны гэрэл асна.
- Ус буцалсны дараа ус буцалгагч хэдэн секундын дотор автоматаар унтарна. АСААХ/УНТРААХ ажиллагааны гэрэл унтарна.
- Түлэгдэх аюултай тул халуун усанд хүрэхээс болгоомжилно уу.
- Ус буцалгахгүй зөвхөн халаах бол АСААХ/УНТРААХ товчлуурыг хүссэн үедээ дээш татан унтрааж болно.
- Ус буцалгагчийг хэрэглэж дууссаны дараа залгуурыг салгана уу.

АНХААРУУЛГА: Ус буцалгагч хэт халалтаас хамгаалагдахаар тоноглогдсон. Энэ нь ус буцалгагчид хангалттай ус байхгүй үед автоматаар өөрөө унтарна. Хэт халж унтарсан тохиолдолд дор хаяж 10 мин амрааж хөргөсний дараа дахин ашиглана уу.

II. ЦЭВЭРЛЭГЭЭ БА АРЧИЛГАА

- Ус буцалгагчийг цэвэрлэхийн өмнө цахилгааны эх үүсвэрээс салгаж, хөргөнө үү.
- Ус буцалгагчийн савыг чийгтэй алчуураар арчиж цэвэрлэнэ, усанд угааж болохгүй. Ус буцалгагчийн аяга таваг угаагч машинаар угааж болохгүй. Цахилгааны холболтыг чийг авсан эсэхийг сайтар шалгана уу.
- Хэрэв ус буцалгагчийн дотор тал ихээр бохирдож, өнгөр тогтсон бол чийгтэй алуураар арчих эсвэл хүнсний сода хэрэглэх нь тохиромжтой. Цэвэрлэж дууссаны дараа ус буцалгагчийг усаар зайлна уу.

САНАМЖ:

- Ус буцалгагчийг цэвэрлэхдээ хурц үзүүртэй зүйл, хатуу зүлгүүр болон хутга ашиглан цэвэрлэж болохгүй. Мөн идимхий болон шатамхай бодис ашиглаж болохгүй.
- Цэвэрлэхийн өмнө цахилгааны эх үүсвэрээс салгаж, бүрэн хөргөнө үү.

III. ГҮН ЦЭВЭРЛЭГЭЭ

Ус буцалгагч нь далд халалтын системтэй учир өнгөр тогтож, шохойжихгүй. Иймд шохойжилт болон өнгөрийг цэвэрлэх шаардлагагүй. Зайлшгүй өнгөр тогтож, шохойжсон тохиолдолд дараах цэвэрлэгээг хийх боломжтой.

Үүнд:

- Ус буцалгагчийг цахилгаанаас салгаж хөргөнө.
- Ус буцалгагчийн цоргоны шүүлтүүрийг салгаж цэвэрлэнэ.
- Ус буцалгагчийн савыг цууны уусмалаар арчиж, хэдэн цаг хүлээнэ үү.
- Ус буцалгагчийг цэвэр усаар дүүргэж буцалгана. Эдгээр үйлдлүүдийг 2 давтаж хийнэ үү.
- Ус буцалгагчийг цэвэрлэхдээ аммион болон бусад төрлийн химийн найрлагатай бүтээгдэхүүнийг хэрэглэж болохгүй, таны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.
- Цэвэрлэхдээ цууны уусмал эсвэл ус буцалгагч цэвэрлэх зориулалтын тусгай цэвэрлэгчийг ашиглана уу.

Хэрэглээнээс гарсан хуучин цахилгаан бараа хаягдал, устгал

Цахилгаан болон электрон тоног төхөөрөмжийн хог хаягдал (Waste Electrical and Electronic Equipment 'WEEE') 2002/96/EC -ын Европ дахь удирдлагууд дараах байдлыг тодорхойлсон байна.

Хуучин цахилгаан барааны хог хаягдлыг энгийн хог хаягдалтай хольж хаяж болохгүй бөгөөд энэ нь байгаль орчны болон хүрээлэн буй орчин, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийн нэг учир эдгээр хохирлыг багасгахын тулд хуучин цахилгаан барааны хог хаягдлыг хотын хог хаягдлаас ялгаж тусад нь устгалд оруулж байх мөн хуучин цахилгаан барааны эд ангиуд дахин ашиглагдах материалд ордог тул тусад нь ялгаж ашиглаж болох хэсгүүдийг дахин ашиглах боломжтой гэж үзнэ.



Энэхүү тэмдэглэгээ нь таны худалдан авсан ахуйн хэрэгцээний цахилгаан болон электрон бараа дээр байвал уг барааг хаях үедээ тусад нь ялгаж байх гэсэн тэмдэг юм.

Худалдан авагч хуучин цахилгаан бараа болон электрон бараа тэдгээрийн хог хаягдлыг хэрхэн хаана устгалд оруулж болох дахин ашиглах, эс ашиглах зэргийг орон нутгийн

захиргаа болон Нэкт Электроникс ХХК – ийн засвар үйлчилгээний төвөөс авч болно. Монгол улсын хэмжээнд хуучин хэрэглээнээс гарсан цахилгаан барааг устгах тухай, хаана хэрхэн хаях талаар тодорхой мэдээлэл хараахан гараагүй ч манай Нэкт Электроникс ХХК нь удахгүй энэ асуудлыг шийдвэрлэх гарцыг олж хэрэглэгч үйлчлүүлэгч танд мэдээлэл хүргэх болно. Бидний амьдралын өлгий болсон байгаль орчноо хамгаалахад хүн бүхний оролцоо хамгаас чухал билээ.

Нэкт Электроникс ХХК – ийн Засвар үйлчилгээний төвийн хаяг: Нэкт Сервис Засварын төв, Ард Аюуш өргөн чөлөө, Баянгол дүүрэг-13, Улаанбаатар хот, Монгол улс.